



## МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2018 оны 10 сарын 30 өдөр

Дугаар А-262

Улаанбаатар хот

Төв банкнаас зээл, санхүүжилт олгоход барьцаалах хөрөнгө болон худалдан авах үнэт цаасны жагсаалтыг батлах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 20<sup>1</sup> дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төв банкнаас банкинд зээл, санхүүжилт олгоход барьцаалах хөрөнгө болон худалдан авах үнэт цаасны жагсаалтыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Төв банкнаас банкинд зээл, санхүүжилт олгоход барьцаалах хөрөнгө болон худалдан авах үнэт цаасны жагсаалтыг шинэчлэх тухай саналыг тодорхой нөхцөл байдал, хэрэгцээ шаардлагыг харгалзан тухай бүр боловсруулж, танилцуулж байхыг Эрсдэлийн удирдлагын алба (Д.Баянзул)-нд даалгасугай.

3.Энэхүү тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газар (А.Энхжин), Тайлан бүртгэлийн газар (Т.Амарсайхан)-г тус тус үүрэг болгосугай.

4.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2015 оны А-131 дүгээр тушаалыг хүчингүйд тооцсугай.

5.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитын газар (Д.Аюуш)-г үүрэг болгосугай.

МОНГОЛБАНКНЫ  
ЕРӨНХИЙЛӨГЧ



Н.БАЯРТСАЙХАН

ТӨВ БАНКНААС БАНКИНД ЗЭЭЛ, САНХҮҮЖИЛТ ОЛГОХОД БАРЬЦААЛАХ ХӨРӨНГӨ БОЛОН ХУДАЛДАН АВАХ ҮНЭТ ЦААСНЫ ЖАГСААЛТ

1. Төв банкнаас (Монголбанк) зээл, санхүүжилт олгоход дараах төрлийн активыг барьцаа хөрөнгөд авна. Үүнд:

Зээл, санхүүжилтийн төрөл	Барьцаа хөрөнгө <sup>1</sup>
<b>1. Нээлттэй захын үйл ажиллагаа</b>	
1.1 Төв банкны репо арилжаа	Төв банкны үнэт цаас, Засгийн газрын үнэт цаас
<b>2. Санхүүжилтийн байнгын хэрэгсэл</b>	
2.1 Репо санхүүжилт	Төв банкны үнэт цаас, Засгийн газрын үнэт цаас
2.2 Өдрийн репо хэлцэл	Төв банкны үнэт цаас, Засгийн газрын үнэт цаас
<b>3. Барьцаат зээл</b>	Төв банкны үнэт цаас, Засгийн газрын үнэт цаас, Хөгжлийн банкны үнэт цаас, банкны хэвийн зээл

2. Төв банкны барьцаа хөрөнгийн эрсдэлийн хямдруулалтын хэмжээ, хувиар

2.1 Тогтмол купонтой үнэт цаасны эрсдэлийн хямдруулалт:

Барьцаа хөрөнгө	Эрсдэлийн хямдруулалт (Барьцаа хөрөнгийн үлдэгдэл хугацаа)					
	0-1 жил	1-3 жил	3-5 жил	5-7 жил	7-10 жил	10+ жил
Төв банкны үнэт цаас	0.5	1.0	1.5	2.0	3.0	5.0
Засгийн газрын үнэт цаас	0.5	1.0	1.5	2.0	3.0	5.0
Хөгжлийн банкны үнэт цаас	1.0	1.5	2.5	3.5	4.5	8.0

2.2 Купонгүй үнэт цаасны эрсдэлийн хямдруулалт:

Барьцаа хөрөнгө	Эрсдэлийн хямдруулалт (Барьцаа хөрөнгийн үлдэгдэл хугацаа)					
	0-1 жил	1-3 жил	3-5 жил	5-7 жил	7-10 жил	10+ жил
Төв банкны үнэт цаас	0.5	2.0	2.5	3.0	4.0	7.0
Засгийн газрын үнэт цаас	0.5	2.0	2.5	3.0	4.0	7.0
Хөгжлийн банкны үнэт цаас	1.0	2.5	3.5	4.5	6.5	10.5

2.3 Банкны хэвийн зээлийн эрсдэлийн хямдруулалт:

Зээлийн үлдэгдэл хугацаа	Эрсдэлийн хямдруулалт
3 жил хүртэл	30
3 жилээс дээш	50

<sup>1</sup> -Барьцаанд авах Засгийн газрын үнэт цаас нь ҮЦТХТ ХХК-д бүртгэлтэй, биет бус үнэт цаас байна.